



ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/99

Бор-Өндөр сум

Мал амьтны шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга
хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, Хэнтий аймгийн Засаг даргын 2026 оны А/156 дүгээр захирамж, Хэнтий аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2026 оны А/22 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээг сумын хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнээр баталсугай.

Ажлын хэсгийн ахлагч

Р.Цэндсүрэн

Нарийн бичгийн дарга

Э.Гуамарал

Гишүүд

И.Энхтуяа

У.Пүрэвсүрэн

С.Байгалмаа

Ч.Саруулмөнх

Б.Мөнх-Оргил

Н.Отгонбилэг

Ц.Бат-Эрдэнэ

Ц.Төртүвшин

Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч

Хүйх 5 дугаар багийн зохион байгуулагч

Бор-Өндөр 1-р Багийн Засаг дарга

Холбоо 2-р Багийн Засаг дарга

Бумбат 3-р Багийн Засаг дарга

Уурхайчин 4-р Багийн Засаг дарга

Хүйх 5-р Багийн Засаг дарга

Өлгий 6-р Багийн Засаг дарга

Ноён Зүлэгт ХХК МЭҮН-ийн захирал,
малын эмч

ЭнТэЧи ХХК МЭҮН-ийн захирал,
малын эмч

2. Мал, амьтны шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх төлөвлөгөөг хавсралтаар баталж, тус арга хэмжээг 2026 оны 04 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийг дуустал зохион байгуулахыг Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч (Р.Цэндсүрэн) -д үүрэг болгосугай.

3. Мал эмнэлгийн төлөвлөгөөт арга хэмжээг орон нутагтаа графикт хугацаанд нь шуурхай хийж гүйцэтгэхийг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн Малын эмч (Ц.Бат-Эрдэнэ, Ц.Төртүвшин) нарт, Мал, амьтны шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх төлөвлөгөөт ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, зохион

байгуулах, ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж дүнг нэгтгэж танилцуулахыг Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч (Р.Цэндсүрэн) -д даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын тамгын газрын дарга (З. Ууганжаргал)-д, гүйцэтгэлийг вакцинжуулалт дууссанаас хойш 7 хоногийн дотор танилцуулж, тарилгын материалыг дээд шатны байгууллагад хүргүүлж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч (Р.Цэндсүрэн) -д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ОТГОНЦЭЦЭГ



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 14 өдөр

Дугаар A/100

Бор-Өндөр сум

Мал амьтны сэг зэм устгал, орчны цэвэрлэгээ,
халдваргүйтгэлийн арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.3.6 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.2.4, 19.2.6, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2026 оны А/29 дүгээр тушаал, Хэнтий аймгийн Засаг даргын 2026 оны А/157 дугаар захирамж, Хэнтий аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2026 оны А/23 дугаар тушаал тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны сэг зэм устгал, орчны цэвэрлэгээ халдваргүйтгэлийн арга хэмжээг сумын хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнээр баталсугай.

Ажлын хэсгийн ахлагч

Р.Цэндсүрэн

Нарийн бичгийн дарга

Э.Гуамарал

Гишүүд

И.Энхтуяа

У.Пүрэвсүрэн

Д.Мөнгөнтуяа

Ч.Саруулмөнх

Б.Мөнх-Оргил

Н.Отгонбилэг

Ц.Мөнхтунгалаг

Ц.Бат-Эрдэнэ

Ц.Төртүвшин

Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч

Хүйх 5 дугаар багийн зохион байгуулагч

Бор-Өндөр 1 дүгээр багийн Засаг дарга

Холбоо 2 дугаар багийн Засаг дарга

Бумбат 3 дүгээр багийн Засаг дарга

Уурхайчин 4 дүгээр багийн Засаг дарга

Хүйх 5 дугаар багийн Засаг дарга

Өлгий 6 дугаар багийн Засаг дарга

Өлгий 6 дугаар багийн зохион байгуулагч

Ноён зүлэгт ХХК МЭҮН-ний захирал, малын эмч

ЭнТэЧи ХХК МЭҮН- ний захирал, малын эмч

2. Мал, амьтны сэг зэмээс малын халдварт өвчин тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор сэг, зэм цуглуулж устгах, орчны цэвэрлэгээ халдваргүйтгэл хийх ажлын 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн 2026 оны 10 дугаар сарын 30-ны дуустал хугацаанд зохион байгуулсугай.

3. Мал эмнэлгийн төлөвлөгөөг арга хэмжээг орон нутагтаа графикт хугацаанд нь шуурхай хийж гүйцэтгэхийг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч (Ц.Бат-Эрдэнэ, Ц.Төртүвшин) нарт, Мал амьтны сэг, зэмийг цуглуулж устгах, орчны

4. халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулахад шаардлагатай халдваргүйтгэлийн бодис, хамгаалах хувцас хэрэгсэл, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч (Р.Цэндсүрэн) -д даалгасугай.

5. Мал, амьтны сэг зэм устгал, орчны цэвэрлэгээ халдваргүйтгэлийн арга хэмжээнд шаардагдах хүн хүч, шатахуунаар хангаж ажиллахыг Засаг даргын тамгын газрын дарга (З. Ууганжаргал)-д, Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Галбадрах)-д, ажлын гүйцэтгэлийг танилцуулж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч (Р.Цэндсүрэн) -д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ОТГОНЦЭЦЭГ



ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/1101

Бор-Өндөр сум

Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний
хугацааг сунгах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Монгол Улсын засгийн газрын 2025 оны 121 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэдийн газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний хугацаагаа сунгуулах хүсэлтийн дагуу иргэдийн газар эзэмшүүлэх гэрээний хугацааг нэгдүгээр хавсралтад, аж ахуйн нэгжийн газар ашиглах гэрээний хугацааг хоёрдугаар хавсралтад заасны дагуу сунгасугай.

2. Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулсан газар эзэмшигч, ашиглагчтай гэрээ байгуулан, гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Т.Эрдэнэзаяа)-д, гэрээнд заасан зориулалт, нөхцөл шаардлагын дагуу газраа эзэмшихийг газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ авсан иргэн, аж ахуйн нэгжийн удирдах ажилтанд үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА

Д.ОТГОНЦЭЦЭГ

Сумын Засаг даргын 2026 оны 04-р сарын 15-ны өдрийн 44-р захирамжийн нэгдүгээр хавсралт

Газар болон эзэмшигчийн мэдээлэл

Д/д	Эзэмшигчийн				Өмнөх Захирамжийн			Өмнөх газрын		Газрын		
	Ургийн овог /иргэн/	Эцэг эхийн нэр /иргэн/	Иргэн /хуулийн этгээд/-ийн нэр	Регистр	Огноо	Дугаар	Нэгж талбарын дугаар	Хугацаа /жил/	Хэмжээ /мкв/	Байршил	Зориулалт	Сунгах хугацаа /жил/
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Баянцагаан	Отгондорж	Балдандорж	СЦ93011713	2009.06.16	50	2322002808	15	24	1-р баг, Их тойруу-2 гудамж, 269 тоот	Автограж	15
2	Боржигин	Төмөрхуяг	Цэнд	СЦ82091819	2022.05.06	A/77	2322003142	2	35	1-р баг, Их тойруу-1 гудамж, 111 тоот	Автограж	15
3	Боржигин	Пүрэвдорж	Бурмаа	СЦ75081346	2010.07.21	76	2322003314	15	100	2-р баг, Найрамдал-1 гудамж, 1106 тоот	Худалдаа, үйлчилгээ	15
4	Боржигин	Шагдар	Ганбат	СЦ68010514	2009.06.16	50	2322002811	15	38	1-р баг, Их тойруу-2 гудамж, 220 тоот	Автограж	15



Сумын Засаг дарга 2026 оны 04-р сарын 15-ны өдрийн захирамжийн хоёрдугаар хавсралт

Газар болон ашиглагчийн мэдээлэл

д/д	Хуулийн этгээдийн нэр	Өмнөх Захирамжийн			Газрын				Сунгах хугацаа /жил/
		Регистр	Огноо	Дугаар	Нэгж талбарын дугаар	Хэмжээ /мкв/	Байршил	Зориулалт	
0	1	2	3	4	5	6	7	8	9
1	Жинтайхэ ГХО ХХК	5218896	2019.12.02	A/196	2322002557	30000	5-р баг, Үйлдвэр-1 гудамж, 104 тоот	Уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламж	5
2	Жинтайхэ ГХО ХХК	5218896	2019.12.04	A/194	2322002556	80000	5-р баг, Үйлдвэр-1 гудамж, 104а тоот		5
3	Лутчулуу ГХО ХХК	5396662	2020.04.20	A/68	2322002915	30000	2-р баг, Шинэ зам-1 гудамж, 105 тоот		5



ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/102

Бор-Өндөр сум

Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээг
шилжүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4 дэх хэсэг, Иргэний хуулийн 70.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэх тухай нотлох баримт бүрдүүлэн өргөдөл гаргасан аж ахуйн нэгжийн эзэмших эрхийн гэрчилгээг Нэгдүгээр хавсралтад зааснаар шилжүүлсүгэй.
2. Газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэн авсан аж ахуйн нэгжийн удирдах албан тушаалтантай гэрээ байгуулан, гэрээний биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Т.Эрдэнэзаяа) -д үүрэг болгосугай.
3. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлж авсан аж ахуйн нэгжид үүрэг болгосугай.
4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Сумын Засаг даргын 2015 оны А/219 тоот захирамжийн Д.Сүхбаатар, 2020 оны А/202 тоот захирамжийн Жинст богд гол ХХК, 2024 оны А/221 тоот захирамжийн Б.Баасандорж нарт холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ОТГОНЦЭЦЭГ



Газар болон эзэмшигчдийн мэдээлэл

д/д	Эрх шилжүүлэн авч буй иргэн, хуулийн этгээдийн нэр	Регистр	Газрын хэмжээ /м ²	Эзэмших хугацаа /жиж	Газрын байршил хаяг	Нэгж талбарын дугаар	Зориулалт	Эрх шилжүүлж буй иргэн хуулийн этгээдийн нэр, регистр	Эрх шилжүүлэх үндэслэл
1	Цээл халив транс ХХК	3320715	100000	9	5-р баг Хүйх, Үйлдвэр-1 гудамж, 111а тоот	2322003095	Уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламж	Жинст богд гол ХХК 6592929	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээ 2025.11.24 №1667
2	Ганц тэнгэр Баатар Энхтуяа	ЛД93061401	24	4	1-р баг Бор-Өндөр, Их тойруу-2 гудамж, 240 тоот	2322003057	Автограж	Зоргол боржигон Дангаа Сүхбаатар ЕТ71081610	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээ 2026.03.27 №165
3	Баяд Цэдэндамба Ундрал	УМ89121507	700	1	3-р баг Бумбат, Нарлаг-5 гудамж, 519 тоот	2322002927	Гэр бүлийн хэрэгцээ	Боржигон Балбардорж Баасандорж СК91032218	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээ 2025.11.07 №557



ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/103

Бор-Өндөр сум

Газар өмчлөх эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4-р зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гэр бүлийн хамтын хэрэгцээнд дундаа хамтран газар өмчилсөн 3 иргэний өмчлөх эрх шилжүүлэх гэрээг харгалзан үзэж дундын өмчлөлийн газрыг үнэ төлбөргүйгээр гэр бүлийн бусад гишүүдэд шилжүүлэн 1-р хавсралтаар өмчлүүлсүгэй

2.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан хоёрдугаар хавсралтад дурдсан, өмчлөх эрхээ сэргээж байгаа 6 иргэнд урьд өмнө гарсан газар өмчлүүлсэн захирамжийн холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцож, хоёрдугаар хавсралтаар мэдээллийг дурдсугай

3.Газар өмчлөх эрх шилжүүлэх гэрээгээр эрхээ шилжүүлсэн иргэнд хууль тогтоомжид заасны дагуу газраа үнэ төлбөргүй өмчлөх эрхтэй болохыг зөвлөсүгэй.

4.Газар өмчлөгчийн хуулийн дагуу хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (З.Ууганжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ОТГОНЦЭЦЭГ

Сумын Засаг даргын 2026
оны ᠒4-р сарын 17-ны
өдрийн ᠕1᠙ тоот
захирамжийн нэгдүгээр
хавсралт

СХ 4.00.᠐3

Өмчлөх эрх шилжүүлэн авагч болон газрын мэдээлэл

№	Өмчлөх эрх шилжүүлэн авагчийн				Газрын		Нэгж талбарын дугаар
	Овог	Эцэг /эх/-ийн нэр	Нэр	Регистр	Байршил	Хэмжээ /м ² /	
1	Тоот	Бадарч	Гантулга	СЦ68022917	4-р баг Уурхайчин, Геологи-16 гудамж, 1604 тоот	560	2322000517
2	Хар Ямаат	Төмөрхуяг	Батнаст	СЦ81081719	4-р баг Уурхайчин, Геологи-16 гудамж, 1614 тоот	800	2322000532
3	Боржигон	Арилд	Нарангэрэл	СЭ84061306	4-р баг Уурхайчин, Жаргалант-1 гудамж, 110 тоот	905	2322003548

Сумын Засаг даргын 2026 оны 04-р сарын
17-ны өдрийн А/103 тоот захирамжийн
хоёрдугаар хавсралт

Өмчлөх эрхээ сэргээж байгаа иргэдийн мэдээлэл

№	Хамтран өмчлөлөөс хасагдагч иргэний				Захирамж
	Овог	Эцэг /эх/-ийн нэр	Нэр	Регистр	
1	Боржигин	Батсүх	Аюурзана	СК75052500	2008.02.25 №27
2	Тоот	Гантулга	Ариунбаяр	СЦ98080411	
3	Тоот	Гантулга	Ариун-Эрдэнэ	СЦ03301406	
4	Өлзийт	Цогтсайхан	Норжмаа	ЛЮ80051267	2008.03.03 №34
5	Хар Ямаат	Батнаст	Гоо-Уянга	СЦ01290429	
6	Тангуд	Бат-Очир	Амартүвшин	СЮ07242114	2013.07.31 №84



ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

Бор-Өндөр сум

2026 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/104

Татварын орлого бүрдүүлэх ажлын хэсгийг
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, 59 дүгээр зүйлийн 5.1.19 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төсвийн орлого бүрдүүлэх, татвар, төлбөр, хураамж, хураах, татварын орлого нэмэгдүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Х.Галбадрах

Нарийн бичгийн дарга:

Ц.Баясгалан

Гишүүд:

И.Энхтуяа

У.Пүрэвсүрэн

Д.Мөнгөнтуяа

Ч.Саруулмөнх

Б.Мөнх-Оргил

Н.Отгонбилэг

Б.Батбаяр

Э.Отгонтунгалаг

Т.Эрдэнэзаяа

Б.Баярбаясгалан

М.Отгонбаатар

Засаг даргын орлогч

Татварын улсын ахлах байцаагч

Бор-Өндөр 1 дүгээр багийн Засаг дарга

Холбоо 2 дугаар багийн Засаг дарга

Бумбат 3 дугаар багийн Засаг дарга

Уурхайчин 4 дүгээр багийн Засаг дарга

Хүйх 5 дугаар багийн Засаг дарга

Өлгий 6 дугаар багийн Засаг дарга

Татвар улсын байцаагч

Байгаль орчны хяналтын улсын
байцаагч

Газрын даамал

Байгаль хамгаалагч

Хэсгийн байцаагч, Цагдаагийн дэслэгч

2.Татварын орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангуулах чиглэлээр холбогдох тооцоо судалгаа, нөлөөллийн ажлыг хийж гүйцэтгэн, татварын орлогыг нэмэгдүүлэхийг ажлын хэсгийн гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ОТГОНЦЭЦЭГ